



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийг зохих үр дүнтэй ашиглаж байгаа ч хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Аудитад аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг даргын тамгын газар, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа, 2016-2022 оны хугацаанд олгогдсон зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг хамрууллаа.

Увс аймагт Хөдөө аж ахуйн салбарт дараах төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хөнгөлөлттэй зээлд иргэн аж ахуйн нэгжүүд хамрагдсан байна. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн төсөл /ЖАЙКА II шат/
- Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл
- Беларусь улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжсэн Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл
- Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл /Дэлхийн банк/

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн төсөл /ЖАЙКА II шат/:

Увс мах маркет ХХК “Мах, махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр өргөжүүлэх төсөл”-өөр 2019 онд 10 жилийн хугацаатай 720.0 сая төгрөгийн зээл авч зориулалтын дагуу хөрөнгө оруулалтаа хийж үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн байна.

Увс мах маркет ХХК нь жилд 100 орчим тонн мах бэлтгэдэг байсан ба төслийн зээлд хамрагдаж үйлдвэрийн хүчин чадлаа өргөтгөснөөр 2022 онд 450 тонн мах, 100 тонн дайвар бүтээгдэхүүн боловсруулж, 2020 онд 171.0 тонн, 2021 онд 296.0 тонн, 2022 онд 437.0 тонн махыг тус тус экспортод гаргасан байна. Түүнчлэн Увс аймгийн малчдын мал махны борлуулалт нэмэгдэж мөнгөн орлого тодорхой хэмжээгээр нэмэгдсэн нь үр өгөөжтэй байна.

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл:

- Дөрвөнбулаг Увс ХХК “Ноос угаах үйлдвэр барих, тоног төхөөрөмж авах” чиглэлээр 500.0 сая төгрөгийн зээл авснаар хоногт 3 тонн ноос ангилж, 1.5 тонн ноос угаах хүчин чадалтай ноос угаах үйлдвэрийг ашиглалтад оруулсан байна. Ингэснээр ноосыг орчин үеийн дэвшилтэт технологиор боловсруулж үнэ цэнийг нэмэгдүүлж импортын барааг орлох бүтээгдэхүүнийг бий болгож, экспортод гаргаж тогтмол ажлын байрыг бий болгож малчдын орлогыг нэмэгдүүлсэн байна.
- Хар цахиур ХХК “Мужаан цех өргөтгөл, тоног төхөөрөмж авах” чиглэлээр 315.0 сая төгрөгийн зээл авснаар хүчин чадлаа өргөтгөж шинээр 4-6 хүнийг ажлын байраар хангасан байна. Түүнчлэн бүтээгдэхүүний гарц нэмэгдсэн ба лазер сийлбэрийн машин ашиглан бүрэн сийлбэртэй монгол гэрийн мод хийж байна. Мөн Улаангом политехник коллежийн мужааны ангийн оюутнуудыг мэргэжлийн дадлага хийх боломжоор хангаж, шинэ тоног төхөөрөмж дээр ажиллуулж сургаж байна.
- Цэнгүүн Чингүүн ХХК “Зочид Буудал зоогийн газраа өргөтгөх” чиглэлээр 400.0 сая төгрөгийн зээл авснаар 50 хүн хүлээн авах хүчин чадал бүхий рестораныг 200 хүртэлх хүн хүлээн авах заал, гал тогоо болон бусад барилга байгууламж тоног төхөөрөмжийн шинэчлэлт, Зочид буудлын 15 өрөөг 26 өрөө болгон шинэ өргөтгөлийн барилга, уурын зуух, халаалтын зуух өрөөний тавилга тохижилтыг иж бүрэн шинэчилсэн байна. Ингэснээр шинээр 6 хүнийг байнгын ажлын байраар ханган ажиллуулж, үйл ажиллагааны орлого 20 сая төгрөгөөс 200 сая хүртэл буюу 10 дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн гадаад, дотоодын аялагчдыг хүлээн авах тохь тухтай орчныг бүрдүүлснээр Увс аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд зохих хувь нэмрийг оруулж байна.

- Номинхөхий туруун ХХК “Тоног төхөөрөмж худалдан авах” чиглэлээр 358.0 сая төгрөгийн зээл авснаар 180 морины хүчтэй трактор, үрлэгч 3 ширхэг, хор бордоо цацагч худалдан авснаар ажлын байрны тоог 4-өөр нэмэгдүүлсэн байна. Мөн өмнө нь 100 га талбайд газар тариалан эрхэлдэг байсан бол 500 га болж нэмэгдэж жилдээ 500 гаруй тонн тариа хураан авах боломжтой болсон байна.

Беларусь улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжсэн Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл:

Тус төсөлд 2 иргэн 6 аж ахуйн нэгж хямрагдаж 7 трактор, 3 хадуур, 3 тармуур, 5 хаман боогч нийлүүлэгдсэн байна. Ингэснээр техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж сайжирч газар тариалангийн салбарт хөрс боловсруулах, ургац хураах зэрэгт тодорхой ахиц дэвшил гарч тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн ургацын хэмжээ нэмэгдсэнээр ашиг орлого тодорхой хувиар өссөн байна. Мөн хадлан өвс авах, өвсийг боох зэрэг үйл ажиллагаанд тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж зохих түвшинд нэмэгдсэн байна.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл:

Төслийн хүрээнд аймгийн Мал эмнэлгийн газарт 4.2 сая төгрөгийн үнэ бүхий цахим хурлын тоног төхөөрөмж хүлээлгэн өгснөөр хурал зөвлөгөөн, сургалтыг цахимаар зохион байгуулах нөхцөл боломж хангагдсан байна. Түүнчлэн сумдад ажиллаж байгаа хувийн малын эмч нарт зориулсан багц цагийн сургалтуудыг зохион байгуулсан байна.

Увс аймагт Хөдөө аж ахуйн салбарт дараах төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд тусламжид иргэн аж ахуйн нэгжүүд хамрагдсан байна. Үүнд:

- Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл /АХБ, Японы ядуурлыг бууруулах сан/
- Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл /АХБ, Японы ядуурлыг бууруулах сан/
- Экспортыг дэмжих төсөл /Дэлхийн банк/
- Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл /Швейцарын Хөгжлийн Агентлаг/
- Монгол ногоо төсөл /Швейцарын Хөгжлийн Агентлаг/

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл /АХБ, Японы ядуурлыг бууруулах сан/:

- Төслийн хөрөнгө оруулалтаар Улаангом сумын 77 өрхөд 2019 онд 4 нэр төрлийн таримлын 187 кг үр, 2020 онд 4 төрлийн таримлын 132.5 кг үр, 2021 онд хүлэмжийн хэмх 11400 ширхэг, лооль 10000 ш, чинжүү 15 грамм, ил талбайн байцайны үр 18000 ш олгож тариалалт хийх боломж нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна. Төслөөс нийлүүлсэн үрүүд нь өндөр ургац авах боломжтой сайн сортын үрүүд байсан байна.
- Улаангом суманд хаврын тариалалтаас намрын ургац хураалт дуустал талбайд ажиллахад шаардлагатай 50 морины хүчин чадалтай трактор хүнсний ногооны иж бүрдлийн хамт, мотоблок 5 ширхгийг хүнсний ногооны иж бүрдлийн хамт олгож техник тоног төхөөрөмжөөр хангаж тариалалтын агротехнологийн хугацаанд багтаан тариалалт, арчилгаа, ургац хураалтыг явуулах боломж нөхцөлийг бүрдүүлж гар ажиллагааг тодорхой хэмжээнд багасгаж хөдөлмөр хөнгөвчлөх нөхцөл бүрдүүлжээ.
- Төсөлд хамрагдсан 77 өрхөд төслийн хөрөнгө оруулалтаар 49 ш буюу 6*20 хэмжээтэй 16 ширхэг, 4*8 хэмжээтэй 33 ширхэг нийлэг хальсан зуны хүлэмж олгож хамгаалалттай хөрсний хүнсний ногооны тариаланг хөгжүүлэхэд томоохон дэмжлэг болсон байна.

- Төсөлд хамрагдсан 3 хоршооны ногоочдын бүлгүүдэд төслийн хөрөнгө оруулалтаар 6 төрлийн хүнсний ногооны таримлын хортон шавж устгах зориулалттай ургамал хамгааллын бодис, шаардлагатай эрдэс бордоог нийлүүлж бүх гишүүдэд хуваарилан олгосноор хүнсний ногооны тогтвортой ургац авах нөхцөл бүрдүүлсэн байна.
- Ногоочдын бүлгийн гишүүдэд зохион явуулсан хүнсний ногооны үйлдвэрлэлийн агротехнологийг эзэмшүүлэх шаталсан танхимын 11 сургалт, дадлага олгох талбайн сургалт 6, нийт 17 удаагийн сургалт зохион явуулсны үр дүнд ногоочдын мэдлэг ур чадвар тасралтгүй дээшилснээр үйлдвэрлэлээ үр ашигтай удирдан явуулах боломж бүрдсэн байна.
- Өвлийн хүлэмж 8*20 хэмжээтэй 4 улирлын хүлэмж шинээр баригдсан. Улаангом суманд анхны 4 улирлын хүлэмж баригдаж 3 сараас 12 сар хүртэл хүнсний нарийн ногоо тариалах боломжтой болсон байна.
- Эх ургамал, сонгино хадгалах зориулалт бүхий 2 тасалгаатай 60 тонны зоорь ашиглалтад орсноор үр үйлдвэрлэгчид эх ургамал болон сонгинолог ургамлаа төрөлжүүлэн хадгалах боломж бүрджээ.
- 2019 оны тариалалтаар төсөлд хамрагдсан өрхүүд нийт 34.1 га талбайд хүнсний ногоо тариалж байсан бол 2021 онд нийт 43.3 га талбайд хүнсний ногоо тариалж талбайн хэмжээ 9.13 га талбайгаар өссөн байна. Хураан авсан ургацын хэмжээ 2019 онд 891.9 тонн байсан ба 2021 онд 1130 тонн хүнсний ногоо хураан авсан нь 2019 онтой харьцуулахад 26.7%-аар нэмэгдсэн мэдээтэй байна.
- Гашууны голын чиглэлд 1,2 км цахилгааны шугам 3 худаг, Улаантолгойн чиглэлд 2 км цахилгааны шугам 2 гүний худаг гаргасан. Цахилгааны шугам татсанаар тухайн чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа бусад тариаланчид үр шимийг хүртэн цахилгаан татан авч үйл ажиллагаагаа явуулж байна. Гүний худаг гарсан нь гандуу хуурай жилүүдэд Гашууны гол тасрах, Улаантолгойн хиймэл нуурын ус хомсодсон үед тариаланчдад их ашиг тусаа өгч байна.
- 2019-2021 онуудад ХХААХҮЯ-аас Улаанбаатар хотод зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээнд давхардсан тоогоор 15 ногоочны зардлыг даан хамруулснаар ногоочдын орлого нэмэгдэж, орон нутагт тариалсан хүнсний ногоогоо УБ хотын хэрэглэгчдэд шууд хямд үнээр нийлүүлсэн байна.

Экспортыг дэмжих төсөл /Дэлхийн банк/:

Увс хүнс хувьцаат компани төсөлд хамрагдаж 2022 онд 30 сая төгрөгийн дэмжлэг авч өөрийн хөрөнгө оруулалт 32.5 сая төгрөг нэмж 3 чиглэлийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

- Брэндбүүк хөгжүүлэлт
- Вэбсайт
- Экспортын зорилтот бүтээгдэхүүний видео контент

Төсөл хэрэгжсэнээр гадаад, дотоодын харилцагчдад мэдээллийг хүргэж бүтээгдэхүүний өнгө үзэмж, савлагаа сайжирснаар, борлуулалт болон экспортын хэмжээ тодорхой хувиар нэмэгдсэн байна.

Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл /Швейцарын Хөгжлийн Агентлаг/:

Төсөл хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан байна. Үүнд:

- **Малчдын байгууллагын бүтцийг бий болгосон байна.** Энэ ажлын хүрээнд 19 суманд “Бэлчээр ашиглагчдын холбоо” төрийн бус байгууллагыг байгуулж 99 бэлчээр ашиглагчдын хэсэгт хуваажээ.
- **Малчдын дундын санг бий болгож Хадгаламж зээлийн хоршоо бий болгох суурийг тавьж өгсөн байна.** 19 сумын Бэлчээр ашиглагчдын хэсэг дээрээ малчдын дундын сан бий

болгож малчин бүр санаачилгаараа 25.0 мянган төгрөгийн хуримтлал үүсгэсэн тохиолдолд ногоон алт төслөөс 25.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэх замаар сум тус бүрд дундын сан үүсгэжээ. Малчид дундын сангаасаа хүүтэй зээл авч арвижуулсан байна.. Нийт 20.0 сая төгрөгөөс дээш дундын сантай сумуудыг Хадгаламж зээлийн хоршоо болгоход зориулж сургалт сургалт зохион байгуулах, байрны тавилга зэргийг үнэгүй олгож Давст, Наранбулаг, Тариалан, Цагаанхайрхан сумдад Хадгаламж зээлийн хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна.

- **Бэлчээрийг малчдын хэсэгт хувааж бэлчээрийн менежментийг сайжруулсан байна.** Малчдын санаачилгаар нутаглаж буй өвөлжөө хаваржааны нутаг бэлчээрийг 99 хэсэгт хувааж гэрээ байгуулан Улсын мэдээллийн санд бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулснаар тухайн хэсгийн бэлчээрийг ургацыг нутаглаж буй газар нутгаар нь бэлчээрийн фото мониторингийн судалгааг жил бүр хийж ургацыг тогтоож даацын гаргаж малчдад мэдээлдэг байна.
- **МАН-н мөшгөх тогтолцоо, малын эрүүл мэнд төсөл хэрэгжүүлжээ.** Увс аймгийн 19 суманд малын эрүүл мэнд төсөл хэрэгжсэнээр малын сүргийн эргэлтийг хийж зах зээлд борлуулах малыг эзмэгжүүлэх, лабораторийн шинжилгээ хийх, зах зээлд борлуулах малын гэрчилгээжүүлэх тоног төхөөрөмжөөр, компьютероор бүх сумын малын эмч нарыг хангаснаар малын гарал үүсэлд хяналт тавих бүрэн боломжтой болжээ.
- **МАН-н эрсдэлийн сангийн журам боловсруулж хэрэгжүүлсэн байна.** МАН-н эрсдэлийн сангийн журмыг боловсруулж сумдад хүргүүлсэн. Сумдаас Бөхмөрөн Давст 2 сумыг сонгон эрсдэлийн сангийн журмыг баг тус бүрээр боловсруулж ИТХ-аар батлуулахад нь мэргэжлийн туслалцаа үзүүлснээр Давст сум уг журмаа Хууль зүйн яамаар батлуулан хэрэгжүүлж эхэлсэн байна.
- **Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулж хэрэгжүүлсэн.** Мерси кор төсөлтэй хамтарч Давст, Сагил, Малчин, Наранбулаг, Өлгий, Өмнөговь сумдын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, бэлчээрийн ашиглалтын журмыг боловсруулж сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна.

Монгол ногоо төсөл /Швейцарын Хөгжлийн Агентлаг/:

Увс аймгийн Үр үйлдвэрлэгчдийн холбоо төсөлтэй хамтарч ажилласнаар дараах үр дүнгүүд гарсан байна. Үүнд:

- Үр үйлдвэрлэгчдийн тоо нэмэгдсэн. Төсөл хэрэгжиж эхлэхэд 26 гишүүнтэй байсан бол одоо тогтмол үйл ажиллагаа явуулдаг 40 гишүүнтэй болсон./
- Хөнгөлөлттэй үнээр 8 ширхэг мотоблок дагалдах хэрэгслийн хамт, автомакс буцалтгүй тусламжаар 3 ширхэг моторт гар сийрүүлэгч, хүнсний ногооны үр цэвэрлэгч, сонгино хураагч, сонгино үрлэгч, сармис үрлэгч, хүнсний ногооны гар үрлэгч, хор цацагч зэрэг тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн.
- Жилд үйлдвэрлэдэг үрийн хэмжээ 4 тонноос 12 тонн болтол нэмэгдсэн ба Монгол улсын улсын хэмжээний үрийн 70 хувийг шинэ болон шинэчилсэн сортын чанартай үрээр хангаж байна.
- Нэг кг үрийн үнэ 10.0-12.0 мянган төгрөг байсан бол 40.0-45.0 мянган төгрөг болж нэмэгдсэнээр борлуулалтын орлого 48.1 сая төгрөгөөс 493.5 сая төгрөг болж өсөж өрхийн орлого өссөн.
- Нийт 5 ширхэг нийлэг хальсан зуны хүлэмж олгосон нь хамгаалалттай хөрсний хүнсний ногооны тариаланг хөгжүүлэхэд томоохон дэмжлэг болсон байна.
- Хүнсний ногооны таримлын хортон шавж устгах зориулалттай ургамал хамгааллын бодис, шаардлагатай эрдэс бордоог хөнгөлөлттэй үнээр олгосноор хүнсний ногооны тогтвортой ургац авах нөхцөл бүрдүүлсэн байна.
- Эх ургамал, сонгино хадгалах зориулалт бүхий 40 тонны зоорь ашиглалтад орсноор үр үйлдвэрлэгчид эх ургамал болон бусад хүнсний ногоо хадгалах боломж бүрджээ.

Түүнчлэн хүнсний ногоо боловсруулах зориулалтай 4 төрлийн тоног төхөөрөмжийг тусламжаар өгсөн байна. Ингэснээр хүнсний ногоо боловсруулах үйл ажиллагаанд ахиц дэвшил гарсан байна.

Төслийн нэгжээс “Чандмань торгон үр” хоршоонд худаг гаргахад 8.8 сая, 5 га газрыг хашаажуулахад 7.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр хоршооны үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг болсон байна.

Мөн Улаангом сумын 10 багт хэрэгжүүлсэн “Жишиг гудамж төсөл”-ийн хүрээнд нэг гудамжны 15 өрхийн дунд 5 ширхэг нийлэг хальсан зуны хүлэмжийг 50%-ийн хөнгөлөлттэй үнээр нийлүүлснээр өрхийн хэрэгцээний нарийн ногоо тариалах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Засгийн газрын шугамаар авсан зээлийг зохих үр дүнтэй ашиглаж байна.
2. Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээний ашиглалт үр өгөөжтэй байна.
3. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зохих үр дүнтэй хэрэгжсэн байна.
4. В.Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.
5. Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд тусламжаар ирсэн хөрөнгүүд төсөл хэрэгжүүлэгч нэгж дээр бүртгэлтэй байгаа ба хэрэгжих хугацаа нь дуусаж байгаа төслүүдийн хувьд хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгуулахаар дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хэрэгжиж дууссан төслийн хүрээнд бий болсон хөрөнгүүдийг төрийн бус байгууллага болон хоршоонд гэрээгээр эзэмшүүлж байна. Цаашид хөрөнгийн өмчлөлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгах.
2. Хүнс хөдөө аж ахуйн салбарын төрийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, салбарын яам, аймаг, сумын удирдлага, орон нутгийн засаг захиргааны байгууллага, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай төслийн нэгж, Хөдөө аж ахуйг дэмжих сантай хэрхэн харилцах, хамтран ажиллах, мэдээлэл солилцох зохицуулалтыг холбогдох хууль, журмуудад тодорхой тусгаж салбарын ажлын уялдаа холбоог сайжруулж, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгуулах саналтай байна.